

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв /мян.төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Гүйтэтгэлийн биелэлт	үнэлгээ
1.ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, ТӨРИЙН УДИРДЛАГА							
Зорилт1:Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хяналт тавих.							
	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, иргэдийн орон нутагт шилжин, тогтвортой суурьших орчин нөхцөлийг бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн зохист тэнцвэрийг хадгалах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, энэ хүрээнд уг тогтоолд заасан арга	500,0	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж ажилласан байдал	Хөдөөгийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд шинэ залуу боловсон хүчинг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор гэр бүлийнх нь хүнийг ажлын байраар хангаж амьдрах орон байраар хангасан. 5 гэр бүл шилжиж ирсэн. Мөн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор нэмэгдэл хөлс, урамшууллыг боломжит хэмжээгээр олгосон.	Монгол Улсын Их Хурлын 2023 оны 93 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр анхаарч ажилласан байна.	Байгууллагат нийт төрийн захиргааны 7, төрийн үйлчилгээний 6, улс төрийн 8 албан хаагч нийт 21 орон тоотой ажиллаж байна. Төрийн албан хаагчдад хагас бүтэн жилээр үр дүнг тооцон ажиллаж урамшуулал олгодог. Хуучин барилгуудад өрөө гарган амьдрах байраар хангасан. Нийт 6 албан хаагч байраар хангагдсан. Байгууллагын зүгээр орон нутагт ажиллах боловсон хүчнийг дэмжих зорилгоор халаалт түрээсийн мөнгө авдаггүй.Шинэ жилийн баяр болон Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр ажилчдын хүүхдүүдэд гарын бэлэг гардуулсан. Мөн ажлаар явахад нь албан томилолт, шатахууны зардалыг олгож, орон нутгийн нэмэгдэлтэй болсноор ажилчдын нийгмийн	100

						асуудлыг шийдвэрлэсэн. Ар гэрийн гачигдал, шинэ гэр, байшин барих, шинэ хүүхэд төрөх зэрэгт байгууллагаас дотоод журмын дагуу 4,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	
	Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг төрийн байгууллага бүр хангаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах	200,0	Төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулан, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг төрийн байгууллага бүр хангаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллах	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, ил тод байдлын үзүүлэлтийг хангасан байна.	Сумын төрийн байгууллага бүр өөрсдийн фэйж хуудсаар үйл ажиллагааныхаа ил тод байдлыг ханган ажиллаж байна. Сумын 100 жилийн ойн баяр болохтой холбогдуулан Шинэ зуун сангийн үйл ажиллагаанд хандив өгсөн иргэдийн мэдээллийг тогтмол нээлттэйгээр байршуулж байна. Төрийн үйлчилгээ авахад төлөх төлбөрийн хэмээг ил тод баршуулан ажиллаж байна. 2024 оны 06 дугаар сард болсон Багийн Иргэдийн Нийтийн хурлаар Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд явж явуулын төрийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд иргэдэд төрийн үйлчилгээ авах цахим сургалт, мэдээллүүдийг өгч ажилласан.	100
1.1	Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж	Бусад төрийн байгууллагуудын дарга нарт хөгжлийн бодлогын баримт	Үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн	Төрийн аудитын газраас хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 2023 оны тайланд хийсэн аудитаар “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах” журмын	100

	хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлэх		ажилласан байх -Хөндлөнгийн болон дотоод аудитаас гаргасан акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төсвийн байгууллагуудад бүрэн хангуулж ажилласан байдал	бичигүүдийг танилцуулж нүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгуулсан.	хүрээнд арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	6.3, 6.4 зэрэг заалтыг хангаагүй албан шаардлага гарсаныг албан шаардлагыг засан албан тоотоор эргэн хариу хүргүүлсэн. Санхүү хяналт, шалгалтын хүрээнд 2023 онд зээл авсан зээлдэгчийн хувийн хэргийн бүрдэл, хяналтын зөвлөлийн тайлан, гэрээний хугацаа дууссан зээлдэгчдийг шүүхийн байгууллагат шилжүүлж зээл төлөлтийн арга хэмжээг бүрэн авсан үнэлгээтэй гарсан. Мөн хувийн хэргийн бүрдэл дутуу байсныг эргэн бүрэн бүрдүүлж, арилгасан. Хоршоо хөгжүүлэх сангаас 2024 оны зээлийн үйл ажиллагааг шалгахаар зөвлөлийн хяналтыг удирдамжийн дагуу 1 удаа явуулсан.	
Зорилт 1.2.Төрийн үйлчилгээг цахимжуулж, төрийн байгууллага хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулан, иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.							
	Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, албан ёсны вэб сайт хөтлөлтийг сайжруулах, мэдээллийг тухай бүр байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудсанд олон нийтэд	2000,0	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль -Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн	Сумын вэб хуудасны мэдээлэл байршуулах ажлыг 1 албан хаагчид хариуцуулан ажиллаж байна.	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, шуурхай,	ЗДТГазрын мэдээллийн самбарт Сумын 2024 оны батлагдсан төсөв, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, 2023 оны жилийн эцсийн Аудитын тайлангийн дүгнэлт, Орон нутгийн ерөнхий орлого, Хоршоо хөгжүүлэх сан, Орон	

	ойлгомжтой хэлбэрээр байрлуулах		хэрэгжилтийг хангаж ажилласан байдал -Монгол Улсын Засгийн газрын 2022 оны "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх" тухай 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан байдал		чирэгдэлгүй хүргэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна	нутгийн хөгжлийн сан, Эрсдэлээс хамгаалах сангийн сар бүрийн мэдээ, өр, авлагын мэдээллийг байршуулсан. 2023 оны Худалдан авах ажиллагааны тайлан, 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Сумын батлагдсан төсөв, Улсын төсөв болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тендерийн урилга, шалгаруулалт, тендерийн гүйцэтгэл, үр дүнг, 2023 оны жилийн эцсийн нэгдсэн тайлан, Үнэлгээний хороо байгуулсан захирамжууд, Худалдан авах ажиллагааны жилийн тайлан, Аудитын дүгнэлтийг Taragt.ov.gov.mn сайт, Tender.gov.mn, shilendans.gov.mn сайт, мэдээллийн самбаруудад байршуулсан. Сумын ИТХуралд Эрсдэлээс хамгаалах сангийн 2019-2023 оны хэрэгжилт, 2023 оны төсвийн тодотгол зэргээс асуудал оруулж, ил тод мэдээллэж ажилласан. Багийн ИНХуралд ОНХСангийн хэрэгжилт, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтын талаар мэдээлэл бэлтгэж	
--	---------------------------------	--	---	--	--	--	--

						танилцуулсан. Ил тод байдлыг хангах ажлын хүрээнд Өвөрхангай Тарагт сумын Засаг даргын Тамгын газар рaгe хуудсанд 2024 оны 01 сараас сум орон нутагт зохион байгуулагдаж байгаа арга хэмжээ, төрийн үйлчилгээ, албан хаагчдын хууль сурталчлах мэдээлэл, ЗДТГазрын хийгдсэн ажил гэх мэт 125 мэдээллийг байршуулсан.	
	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://erp.e-mongolia.mn/)-ийг нэвтрүүлэх, мэдээлэл солилцох, албан бичиг солилцооны дундын системд холбогдох ажлыг эрчимжүүлэх	1000,0	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://erp.e-mongolia.mn/)-д нэвтэрсэн байгууллагын тоо	-Дотоод удирдлагын системд бүртгүүлсэн.	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://erp.e-mongolia.mn/)-д тухайн орон нутгийн төрийн байгууллагуудад бүрэн нэвтрүүлж ашиглаж хэвшсэн байна.	Төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (https://erp.e-mongolia.mn/)-д Засаг адргын Тамгын газар холбогдсон. Одоогоор бүтэц орон тоо болон албан хаагчдаа бүртгэх ажил хийгдэж байна.	
	Орон нутгийн төрийн болон төрийн өмчит байгууллагын мэдээллийн систем, сүлжээний аюулгүй байдлыг хангуулах арга хэмжээ авах, “Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах	200,0	Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах	-Кибер аюулгүй байдлын талаар 1 удаа байгууллагын албан хаагчид сургалтанд хамрагдсан.	Халдлага, зөрчил гараагүй байх	Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэсээс Кибер аюулгүй байдлын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтанд 87 иргэн хамрагдсан. Төрийн байгууллага бүр дотоод журмандаа кибер аюулгүй байлыг хангах тухай заалт оруулсан. Засаг даргын Тамгын газар кибер аюулгүй	

						байдлыг хангах дотоод журамтай болсон.	
Зорилт 1.3.Төрийн албаны тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.							
	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулж, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох (Төрийн албаны тухай хуулийн 55.3)	4000,0	-Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал - Байгууллагын ёс зүйн дэд зөвлөл, дотоод хяналт шалгалтын ажлын чанар	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу 2000,0 төгрөг зарцуулсан.	-Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 9 дүгээр хавсралт, 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, дүгнэсэн байна. -Томилгоотой холбоотой гомдол, маргаан гараагүй байна.	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө боловсруулан Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2 албан хаагчын ар гэрт ажил явдал гарахад 800000 төгрөг, 2 ажилтан эмнэлэгт хэвтсэн үед тус бүр 50000 төгрөг дундын сангаас шилжүүлсэн. Сэвлэгээ үргээсэн 2 албан хаагчийн 3 хүүхдэд 300000 төгрөг, шинэ байранд орсон 2 албан хаагчид 600000 төгрөг, ОУХЭрхийг хамгаалах өдрөөр 21 албан хаагчид гарын бэлэг 315000 төгрөгт олгосон. 3 албан хаагчийн зөөври компьютер, 17 албан хаагчийн ширээ, сандал, шүүгээг шинэчилсэн. Хүний нөөцийг чадавхижуулан зорилгоор салбар бүрийн зохион байгуулсан сургалт,	

						зөвлөгөөнд албан хаагчдыг бүрэн хамруулж томилолт шатахууны зардлыг олгосон. Мөн Удирдлагын академд 1 албан хаагч магистраар суралцаж байна. Үүнд цалинтай чөлөө олгон дэмжлэг үзүүлсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийг үнэлэхдээ журмын дагуу ёс зүй харилцаа хандлагыг хамт олноор нь үнэлүүлэн дүгнэж байна.	
	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо (ХНУМТ) цахим системийн хөтлөлт, ашиглалт, мэдээллийн баяжилтыг тогтмол шинэчилж, байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр ханган, алдаатай мэдээллийг тухай бүр залруулах, системийн хамгаалалт, нууцлалыг хангаж ажиллах	-	-Баримт бичигтэй тулган үнэн зөв мэдээллийг бүрэн оруулсан байдал -Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үүрэгжүүлсэн байдал -Нууцын баталгааг гаргуулсан байдал	Төрийн албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчилдэг	Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ыг мөрдөж ажилласан байна.	Байгууллагын хүний нөөц ийн системд тухай бүр шинэчлэлүүдийг хийж байна. Цалин хөлс өөрчлөгдсөнтэй холбогдуулан 21 албан хаагчийн цалингийн мэдээлэл, нийгмийн даатгалын төрөл, орон нутгийн нэмэгдэлийг өөрчилж оруулсан. Зэрэг дэв 2 албан хаагч шинэчлэгдсэн. Тайлан цэснээс төрийн албан хаагчдын улсад болон төрийн албанд ажилласан жилийн судалгааг 1 удаа гаргасан. Бусад төрийн байгууллагуудад цалин шинэчлэгдсэнтэй холбогдуулан хариуцсан мэргэжилтэнгүүдэд арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан.	

	Бусад төрийн байгууллагууд төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах, сургалт хийх, ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг сумын хэмжээнд зохион байгуулах, мэргэшил арга зүйгээр хангах	300.0	-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах талаар зохион байгуулсан сургалтын тоо - Ёс зүйн дэд хорооны тоо	-	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын зөрчлийн үзүүлэлт буурсан байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн журамласан байна.	Сумын төсөвт байгууллагууд ёс зүйн дэд хороогоо шинэчилэн байгуулж төлөвлөгөө гарган ажиллаж байна. Засаг даргын Тамгын газрын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүд болон төсөвт байгууллагуудын дарга нарт сургалт хийсэн. Сургалтад 20 хүн хамрагдсан. Байгууллагын алба хаагчдад 2 удаа сэтгэл зүйч урин хамт олны уур амьсга, хувь хүний хөгжлийн талаар сургалт авч албан хаагчид сэтгэл зүйчтэй уулзаж зөвлөгөө авсан.	
ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАР							
Зорилт 2.1. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг оновчтой арга, хэлбэрээр зохион байгуулж, цахим технологид суурилсан эрх зүйн сургалт, сурталчилгааг хөгжүүлнэ.							
2.1	Сумдад эрх зүйн танхим (булан) байгуулах ажлыг дуусгах, хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг нэмэгдүүлэх	2000.0	Зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн тоо	-	200-с доошгүй иргэнд хууль зүйн зөвлөгөө өгсөн байна.	Хууль эрх зүйн зөвлөгөө мэдээллийг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад утсаар болон биечлэн нийт 320 иргэнд тухай бүр хүргэн ажиллаж байна. БИНХ-аар явж малчдад малчины тухай хуулийн танилцуулгыг хүргэж ажиллав. Бусад байгууллага, албан хаагчидтай холбогдолтой хууль	

						тогтоомжуудыг гарсан даруй мэдэгдэж танилцуулдаг.	
2.2	Эрх зүйн сургалт, сурталчилгааны 2024 оны нэгдсэн төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	-	90 доошгүй хувьтай хэрэгжүүлсэн байна	Эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөг 3 бүлэг, 24 зорилт арга хэмжээтэй батлуулж эхний хагас жилийн байдлаар сумын хэмжээнд 35 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулснаас нийт 2.050 иргэд, албан хаагчид хамрагдсан байна.	
2.3	Сумын хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, тайлагнах. Цахим хуудаст байршуулж мэдээлэх.	100.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	Жил бүр төлөвлөгөө гарган батлуулж, албан тушаалтнуудад зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.	Сумын урд оны үзүүлэлт ахисан байна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө гарган сумын Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. 6 албан хаагчийн ХАСХОМ мэдүүлгийг хугацаанд нь авсан. ОНХСангийн ажлын хэсэгт орж байгаа албан хаагчид болон ХЭДС-ийн төсөл хэлэлцэх ажлын хэсгийн гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг тухай бүр бөглөж хэвшсэн.	
2.4	Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийг томилохын өмнө (түр орлон болон хавсран, туршилтын хугацаагаар) Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулах, томилогдсоны дараа 30 хоногийн дотор ХАСХОМ	200,0	Хуулийн хугацаанд ХАСУМ хянуулсан болон ХОМ гаргасан албан тушаалтны тоо	12 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлэг өгсөн. 6 иргэн ХАСУМ мэдүүлсэн.	Хуулийн хугацааг баримталсан байна.	Хөрөнгө орлогын мэдүүлгийг 6 албан хаагчаас хугацаанд нь мэдүүлгийг авч баталгаажуулсан. Засаг даргын орлогчид нэр дэвшигдсэн 1 иргэний ХАСУМ-ыг хянуулахаар АТГ-т хүргүүлсэн.	

	гаргах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулан, хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах.						
ГУРАВ.БАТЛАН ХАМГААЛАХ, ОНЦГОЙ БАЙДЛЫН САЛБАР							
Зорилт 3.1. Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.							
	Ээлжит цэрэг татлагын бэлтгэл ажлыг хангаж, зохион байгуулах, хугацаат цэргийн алба хааж буй дайчдын ар гэрт дэмжлэг туслалцаа үзүүлэх	1500,0	Цэрэг татлагад хамрагдсан хувиар	Цэрэг татлагад 93 хувь хамрагдсан.	18-25 насны залуучуудыг татлагад оруулах 26 настнуудтай төлбөрийн тооцоо хийх	1-р ээлжийн цэрэг татлага 2024 оны 04 сарын 25-26-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. 25-ны өдөр эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдаж 26-ны өдөр цэрэг татлагын үзлэгээр орж нийт 8 залуу тэнцэж цэргийн ангийн үзлэгээр 3 залуу чөлөөлөгдөж 5 залуу цэргийн албанд мордсон. 2 залуу УБ хотруу дотоодын цэргийн 805-р ангид алба хааж, 3 залуу ХЦ 131-р ангид алба хааж байна.Цэргүүдээс ирсэн талархлын захидлыг тангаргын баярын товтой ар гэрт нь хүлээлгэн өгсөн. Цэрэг татлагын ирц 94 хувьтай хамрагдсан. 26 настай цэргийн албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас 20 залуу чөлөөлөгдөж 3 залуу мөнгөн төлбөрийн торгууль тавигдсан.	
	Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар “Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө”	350,0	Дайчилгааны төлөвлөгөөг шинэчлсэн байдлаар	Дайчилгааны төлөвлөгөөг тодотгосон	Дайчилгааны төлөвлөгөөнд тусгагдах статистик мэдээллүүдийг шинэчлэх, хүн,	Цэргийн тоо бүртгэлийг 1-р сард зохион байгуулж үүний дагуу дайчилгааны төлөвлөгөөг тодотгож 40 хүн, 8 авто машиныг	

	батлагдсантай уялдуулан Аймгийн болон сумдын дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах				техникийн томилгоог шинэчлэх	томилгоожуулж аймгийн Цэргийн штабт нэг хувь Тамгын газарт нэг хувь үйлдсэн.	
	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг ханган, Төвийн бүсийн 3 сум орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн зарим бүрэлдэхүүнтэй “Хээрийн дадлага” сургалтыг зохион байгуулах; (Нарийнтээл, Хайрхандулаан, Тарагт)	2000,0	Дадлага сургуулилан д оролцсон иргэдийн тоогоор	-	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөнд тодотгол хийсэн байна. Хээрийн дадлага сургуулилан томилгоот нэгжүүдийг бүрэн оролцуулсан байна.	Хугацаа хойшилсон.	
	Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг зохион байгуулах	5000,0	Дадлага сургуульд оролцсон иргэдийн тоогоор	-	Дадлага сургууль зохион байгуулж, мэргэжлийн анги болон иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг чадварыг олгосон байна.	2024 оны 11 дүгээр сарын 14- 16-ны өдрүүдэд Гамшгийн иж бүрэн дадлага сургуулийг амгийн Онцгой байдлын газартай хамтран зохион байгуулж, 82 албан хаагч, иргэд оролцов. Онцгой комисс, мэргэжлийн ангиуд, сайн дурын хэсгийнхэнд гамшгийн үед ажиллах дадлага сургуулилт хийсэн. Мөн Төрийн байгууллагуудын гамшгаас хамгаалан төлөвлөгөөнд тодотгол хийж ЕБС-ийн сурагчид, ард иргэд, төрийн албан хаагчдад гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан.	

БАТАЛГААЖУУЛСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГАХ.ДАШДЭЛЭГ

2024 оны сарын өдөр

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГАБ.БАТЦЭЦЭГ

2024 оны сарын өдөр

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТАРАГТ СУМ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2024 он